



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/260

Мандалговь

Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн
сантехникийн ажлын нэмэлт санхүүжилт, Сайнцагаан
сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн Б байрны
дээврийн ажлын зураг, төсвийг шалгах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "а", "Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Адаацаг сумын Сургуулийн сантехникийн ажлын нэмэлт санхүүжилт, Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн Б байрны дээврийн ажлын зураг, төсвийг шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|-----------------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Нарийн бичгийн дарга: | Э.Энхмэнд (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга) |
| Гишүүд: | С.Бат-Оргил(Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын Захирагч) Ч.Уранчимэг (Адаацаг сумын Засаг дарга) Г.Мягмарсүрэн(Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн захирал) Б.Даваажаргал(Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал) Э.Дүүрэнжаргал(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн) Т.Базардар(Мандал харш ХХК-ийн захирал) |

2. Ажлын зураг, төсвийг газар дээр нь шалган дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210900